



БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ  
ДАХЬ САЛБАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/211/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
Мөрөн сум  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг  
Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

Бизкон аудит ХХК-ийн  
Ахлах аудитор Ч.Мөнхбаяр  
Утас: 99996784 Цахим хаяг: [mm.bayar0711@gmail.com](mailto:mm.bayar0711@gmail.com)

Аудитор: Л.Пунсал-орлом  
Утас: 88908680 Цахим хаяг: [punsaa73@gmail.com](mailto:punsaa73@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол улс



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/170  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН  
НЭГДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Г.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>85,936,272.90</b>	<b>95,920,400.50</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,936,272.90	95,920,400.50
354	Хангамжийн материал	85,936,272.90	95,920,400.50
35410	Бичиг хэргийн материал	599,000.00	102,500.00
35420	Аж ахуйн материал	16,500.00	00.00
35460	Хүнсний материал	102,600.00	4,028,815.00
35470	Бусад хангамжийн материал	85,218,172.90	91,789,085.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,095,184,469.34</b>	<b>1,113,362,545.52</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,095,184,469.34	1,113,362,545.52
392	Биет хөрөнгө	949,306,969.18	967,337,645.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,046,818,028.00	1,046,818,028.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-142,626,607.92	-165,613,032.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,235,310.00	76,342,333.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,338,738.86	-22,768,681.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,698,188.20	36,256,248.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,845,283.24	-11,709,294.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,078,899.00	10,834,399.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,443,570.00	-2,822,354.80
39217	Ном	2,730,744.00	00.00
393	Биет бус хөрөнгө	145,877,500.16	146,024,900.16
39301	Програм хангамж	737,000.00	147,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-681,999.84	55,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	145,822,500.00	145,822,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,181,120,742.24</b>	<b>1,209,282,946.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,527,996.00</b>	<b>00.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,527,996.00	00.00
413	Өглөг	1,527,996.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,527,996.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,179,592,746.24</b>	<b>1,209,282,946.02</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,179,592,746.24	1,209,282,946.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,401,125.00	265,401,125.00
51101	Өмч: - төрийн	265,401,125.00	265,401,125.00
512	Хуримтлагдсан үр дүн	830,814,556.24	860,504,756.02
51210	Өмнөх үеийн үр дүн	830,814,556.24	830,814,556.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	29,690,199.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	83,377,065.00	83,377,065.00
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	00.00	00.00
51600	Нөөцийн сан	00.00	00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,181,120,742.24</b>	<b>1,209,282,946.02</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>661,468,500.00</b>	<b>680,453,781.08</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>581,023,600.00</b>	<b>595,482,481.08</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,248,500.00	34,278,531.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,248,500.00	34,278,531.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,248,500.00	34,278,531.08
122	<b>Тусламжийн орлого</b>	00.00	20,395,250.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	20,395,250.00
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	575,775,100.00	540,808,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	575,775,100.00	540,808,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,444,900.00</b>	<b>84,971,300.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	315,000.00	3,651,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,792,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	859,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	80,129,900.00	81,319,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,129,900.00	81,319,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>658,497,075.99</b>	<b>625,956,187.44</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>658,497,075.99</b>	<b>625,956,187.44</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	618,878,852.42	618,501,724.54
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	396,089,200.00	408,644,500.00
210101	Үндсэн цалин	310,082,090.15	298,984,405.51
210102	Нэмэгдэл	48,831,456.39	71,142,343.91
210104	Урамшуулал	37,175,653.46	38,517,750.58
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,378,000.00	53,128,096.82
210201	Тэтгэврийн даатгал	36,334,400.00	37,654,197.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,893,300.00	4,187,477.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,326,400.00	3,262,621.84
210204	Ажилгүйдлийн даатгал	802,200.00	699,255.46
210205	Эрүүл мэндийн даатгал	8,021,700.00	7,324,544.89
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,781,828.43	70,037,874.28
210301	Гэрэл, цахилгаан	3,265,973.26	2,686,011.52
210302	Түлш, халаалт	60,574,667.17	61,480,684.76
210303	Цэвэр, бохир ус	3,941,188.00	5,871,178.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,626,406.00	11,577,508.00
210401	Бичиг хэрэг	2,514,400.00	696,750.00
210402	Тээвэр, шатахуун	277,500.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	692,200.00	279,900.00
210404	Ном, хэвлэл	00.00	54,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,422,438.00	1,788,200.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,187,100.00	2,435,430.00
210408	Бараа материал акталсны зардал	6,532,768.00	5,983,228.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>44,434,071.00</b>	<b>23,659,675.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,585,900.00	995,000.00
210502	Хоол, хүнс	42,848,171.00	22,664,675.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,091,000.00</b>	<b>5,634,900.00</b>
210604	Урсгал засвар	4,091,000.00	5,634,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>451,800.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	451,800.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,005,700.00</b>	<b>2,199,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	705,700.00	1,479,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,020,846.99</b>	<b>43,619,370.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,855,400.00	2,561,359.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,693,800.00	6,565,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,471,646.99	34,492,811.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,618,223.57</b>	<b>7,454,462.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>810,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>2,190,825.72</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,190,825.72
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>38,808,223.57</b>	<b>4,263,637.18</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,808,223.57	4,263,637.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,971,424.01</b>	<b>54,497,593.64</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>178,500.28</b>	<b>24,807,393.86</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,814,743.86
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	178,500.28	21,992,650.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-178,500.28</b>	<b>-24,807,393.86</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,792,923.73</b>	<b>29,690,199.78</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,578,625.00	16,943,555.00	-49,764,815.34	86,757,364.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	119,578,625.00	16,943,555.00	-49,764,815.34	86,757,364.66
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,058,318.76	-9,058,318.76
C08	2020 оны 12-р	265,401,125.00	83,377,065.00	830,814,556.24	1,179,592,746.24

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	сарын 31-нээрх үлдэгдэл				
D01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	265,401,125.00	83,377,065.00	830,814,556.24	1,179,592,746.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,401,125.00	83,377,065.00	830,814,556.24	1,179,592,746.24
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,690,199.78	29,690,199.78
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,401,125.00	83,377,065.00	860,504,756.02	1,209,282,946.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>656,220,000.00</b>	<b>625,780,000.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	575,775,100.00	540,808,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	575,775,100.00	540,808,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	575,775,100.00	540,808,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>80,444,900.00</b>	<b>84,971,300.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	3,651,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,792,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	859,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>80,129,900.00</b>	<b>81,319,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	80,129,900.00	81,319,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>643,959,200.00</b>	<b>625,780,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>643,959,200.00</b>	<b>625,780,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>604,340,976.43</b>	<b>618,325,537.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>396,089,200.00</b>	<b>408,644,500.00</b>
210101	Үндсэн цалин	310,082,090.15	270,730,431.54
210102	Нэмэгдэл	48,831,456.39	99,102,265.53
210104	Урамшуулал	37,175,653.46	38,811,802.93
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,378,000.00</b>	<b>54,656,092.82</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,334,400.00	37,796,992.82
210202	Тэтгэмжийн даатгал	3,893,300.00	4,086,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,326,400.00	3,782,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	802,200.00	817,300.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	8,021,700.00	8,172,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67,781,828.43</b>	<b>70,037,874.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,265,973.26	2,686,011.52
210302	Түлш, халаалт	60,574,667.17	61,480,684.76
210303	Цэвэр, бохир ус	3,941,188.00	5,871,178.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,635,718.00</b>	<b>7,226,630.00</b>
210401	Бичиг хэрэг	1,107,200.00	760,800.00
210402	Тээвэр, шатахуун	277,500.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	692,200.00	279,900.00
210404	Ном, хэвлэл	15,000.00	488,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,455,838.00	1,992,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,087,980.00	3,365,030.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>61,213,730.00</b>	<b>29,483,890.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,038,900.00	995,500.00
210502	Хоол, хүнс	38,360,430.00	26,590,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,814,400.00	1,897,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,091,000.00</b>	<b>37,090,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	15,000,000.00
210602	Тавилга	00.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	4,091,000.00	10,090,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>451,800.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	451,800.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,072,300.00</b>	<b>2,204,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	772,300.00	1,484,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	720,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,627,400.00</b>	<b>8,981,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,855,400.00	2,108,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,772,000.00	6,873,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,618,223.57</b>	<b>7,454,462.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>810,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	810,000.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>38,808,223.57</b>	<b>2,190,825.72</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,808,223.57	2,190,825.72
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>4,263,637.18</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,263,637.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>12,260,800.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>12,260,800.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,260,800.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>12,260,800.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,260,800.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>-12,260,800.00</b>	<b>00.00</b>

	ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	622,128,300.00	615,673,837.10	6,454,462.90	99.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	622,128,300.00	615,673,837.10	6,454,462.90	99.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	621,128,300.00	614,673,837.10	6,454,462.90	99.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	408,646,500.00	408,644,500.00	2,000.00	100.00
210101	Үндсэн цалин	278,087,000.00	270,730,431.54	7,356,568.46	97.40
210102	Нэмэгдэл	103,037,100.00	99,102,265.53	3,934,834.47	96.20
210104	Урамшуулал	27,522,400.00	38,811,802.93	11,289,402.93	141.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55,167,300.00	54,656,092.82	511,207.18	99.10
210201	Тэтгэврийн даатгал	38,821,400.00	37,796,992.82	1,024,407.18	97.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,086,500.00	4,086,500.00	00.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,269,200.00	3,782,400.00	-513,200.00	115.70
210204	Ажилгүйдлийн даатгал	817,300.00	817,300.00	00.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,172,900.00	8,172,900.00	00.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	72,228,700.00	70,037,874.28	2,190,825.72	97.00
210301	Гэрэл, цахилгаан	3,774,000.00	2,686,011.52	1,087,988.48	71.20
210302	Түлш, халаалт	62,146,000.00	61,480,684.76	665,315.24	98.90
210303	Цэвэр, бохир ус	6,308,700.00	5,871,178.00	437,522.00	93.10
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,284,200.00	5,218,930.00	65,270.00	98.80
210401	Бичиг хэрэг	585,800.00	585,800.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00	00.00	100.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,800.00	279,900.00	305,900.00	47.80
210404	Ном, хэвлэл	488,200.00	488,200.00	00.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,124,400.00	3,365,030.00	-240,630.00	107.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,415,700.00</b>	<b>29,483,890.00</b>	<b>1,931,810.00</b>	<b>93.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	995,500.00	995,500.00	00.00	100.00
210502	Хоол, хүнс	28,467,400.00	26,590,890.00	1,876,510.00	93.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,952,800.00	1,897,500.00	55,300.00	97.20
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,090,900.00</b>	<b>36,090,900.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	00.00	100.00
210602	Тавилга	12,000,000.00	12,000,000.00	00.00	100.00
210604	Урсгал засвар	9,090,900.00	9,090,900.00	00.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>488,200.00</b>	<b>00.00</b>	<b>488,200.00</b>	
210702	Дотоод албан томилолт	488,200.00	00.00	488,200.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,531,100.00</b>	<b>2,204,000.00</b>	<b>327,100.00</b>	<b>87.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,781,100.00	1,484,000.00	297,100.00	83.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	720,000.00	30,000.00	96.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9275700.00</b>	<b>8337650.00</b>	<b>938,050.00</b>	<b>89.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,464,600.00	1,464,600.00	00.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,811,100.00	6,873,050.00	938,050.00	88.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1000000.00</b>	<b>1000000.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	00.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ</b>	<b>622,128,300.00</b>	<b>615,673,837.10</b>	<b>6,454,462.90</b>	<b>99.00</b>

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ҮҮСВЭР				
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	540,808,700.00	536,545,062.82	4,263,637.18	99.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	540,808,700.00	536,545,062.82	4,263,637.18	99.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	81,319,600.00	79,128,774.28	2,190,825.72	99.00
132001	Орон нутгийн төсвөөс	81,319,600.00	79,128,774.28	2,190,825.72	99.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	00.00	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.00	00.00	00.00	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	00.00	00.00	00.00	
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	37.00	37.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	00.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,651,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,651,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,651,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,007,700.00
210401	Бичиг хэрэг	175,000.00
210402	Тээвэр, шатахуун	40,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,792,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	644,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	644,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,651,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,651,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,441,700.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардал, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг Мөрөн сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны А/07 тоот тушаалаар

дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 23 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 658.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28.2 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	00
Авлага	00	00	00
Урьдчилгаа	00	00	00
Бараа материал	85.9	95.9	10.0
Үндсэн хөрөнгө	1,095.2	1,113.4	18.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,181.1</b>	<b>1,209.3</b>	<b>28.2</b>
Өр төлбөр	1.5	00	-1.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,179.6	1,209.3	29.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,181.1</b>	<b>1,209.3</b>	<b>28.2</b>

Тайлант онд БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр 16 нэр төрлийн 16.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой

24 нэр төрлийн 26.8 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг дахин үнэлж 12.3 сая төгрөгөөр орлого авсан, төсвийн хөрөнгөөр 21 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хөрөнгө, нийт 55.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 12 нэр төрлийн 4.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 37 нэр төрлийн 2.7 сая төгрөгийн ном, нийт 7.6 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын тушаал, шийдвэрийг үндэслэн акталж устгасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 511.1 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 8.9 сая төгрөгөөр бууруулж 728.1 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллагын төсөвт Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ний 01 тоот тогтоолоор төсвийг 72.3 сая төгрөгөөр хасах зохицуулалт, Хөвсгөл аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 33.7 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалт, нийт 106.0 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалтыг хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 622.1 сая төгрөг болгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 622.1 сая төгрөгийн төсөв баталсан ба 540.8 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 81.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 540.8 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 81.3 сая төгрөг, нийт 622.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 615.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 6.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 615.7 сая төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 97.0 хувийн, хангамж, бараа материалын зардал 98.8 хувийн, нормативт зардал 93.9 хувийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 87.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

**Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/**

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>71801</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр</b>	<b>622.1</b>	<b>615.7</b>	<b>6.4</b>	<b>99.0</b>
80109	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	81.3	79.1	2.2	97.3
<b>80802</b>		1.0	1.0	0	100
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	28.5	26.6	1.9	93.4
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	334.9	329.7	5.2	98.4

81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	176.4	179.3	-2.9	101.6
-------	--	-------	-------	------	-------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.2 сая төгрөг, нийт 3.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр бичиг хэрэг, тээвэр шатахуун, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал, хог хаягдал, хортон мэрэгчдийг устгах зардлуудад 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд биет болон биет бус хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэх, зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу шалгахад асуудалтай зүйл илэрсэнгүй.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад хэмнэлтийн тооцоогоор 9.5 сая төгрөгийн хэтрэлттэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

МУ-ын ерөнхий аудиторовын 2021 оны 10 дугаар сарын 08-н ы өдрийн А/92 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу шалгахад алдаа зөрчил илэрсэнгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 74.3 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 265.4 сая төгрөг байгаа ба 191.1 сая төгрөгөөр зөрүүтэй мөн эрхлэгч солигдсоныг бүртгүүлээгүй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 28.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 28.4 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдсан алдаа байхгүй болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Зардалтай холбоотой асуудал**

### **1.1. Илрүүлэлт:**

Бараа үйлчилгээний бусад зардлаас 1.4 сая төгрөгийг шагналд зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж хэвших.

## **2. Зардалтай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Тайлант онд багаж, техник хэрэгсэл, тавилгын зардлаас 27.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь ЗГ-ын 43 дугаар тогтоолын 1.4-д "энэ тогтоол батлагдахаас

өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, журам, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. **Төрийн өмчтэй холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 74.3 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 265.4 сая төгрөг байгаа ба 191.1 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж шинэчилж бүртгүүлэх.


Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС:  
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




/А.ЭРДЭНЭБААТАР/

АУДИТЫН МЕНЕЖЕР:



/Э.БАТ-ЭРДЭНЭ/ 01/25

АХЛАХ АУДИТОР



/Г.ЭРДЭНЭЧИМЭГ/ 2.24

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР




/М.МӨНХБАЯР/

Огноо: 2022.02.24

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР



/Л.ПУНСАЛ-ОРЛОМ/

Огноо: 2022.02.24

